



СОНСОГЧ ОЮУТНЫ ЯРИХ ЧАДВАРЫГ ХӨГЖҮҮЛХЭД КЛУБЫН ОРОЛЦОО

Б.БАЯРСАЙХАН

*Хууль сахиулахын их сургуулийн
Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн
багш, магистр*

Хууль сахиулахын их сургууль төгсөгчид нь төрийн нэрийн өмнөөс ард, иргэдтэй нүүр тулан харьцааж хууль сахиулах эрхэм үүрэгтэй тул харьцааны ямар нэгэн дутагдалгүй байх чухал шаардлагыг нөхцөлдүүлж байдаг. Энэ талын үйл ажиллагаа өнөө үед сонсогч оюутны ярих, илтгэх чадварыг хөгжүүлэх нь чухал шаардлагатай байна. Сонсогч, оюутны ярих чадвар сулаас шалтгаалан харилцааны хэм хэмжээ алдагдах нь нийгэмд олон сөрөг үр дагавар үзүүлэх нь зайлшгүй.

Энэ илтгэлийн зорилго нь сонсогч оюутны ярих чадварыг дээшлүүлхэд анхаарах асуудлуудын хүрээнд клубээр дамжуулан нөлөөлийг сонсогч оюутны дунд өрнүүлснээр тэдний итгэл үнэмшилийг төгелдөржүүлэн өөрийгөө зөв илэрхийлэх чадварт сургахад чиглэгдэнэ.

Иймд эхлээд ярих чадварын тухай авч үзье

1. Нийгмийн харилцаа хурдацтай хөгжиж байгаа өнөө үед хүн өөрсдийн итгэл үнэмшилд тулгуурласан харилцааг зөв сонгох нь чухал байдаг. Итгэл үнэмшил хэдий чинээ зөв тогтоно төдий чинээ амжилт гаргах нь зайлшгүй. Итгэл үнэмшилийн хамгийн чухал хэрэгсэлийн нэг бол хэл яриа буюу ярих чадвар байдаг.

Хэл ярианы чадвар гэж дан ганц үг хэлээр шийдвэрлэгдэх асуудал биш түүнийг хэзээ, хаана, ямар хэлбэр /дуугүй байх, биеийн хөдөлгөөн, сэтгэл хөдлөл, инээх, уурлах, хувцаслалт гэх мэт/ -ээр илэрхийлэх нь чухал. Харилцагч субъектэд нэн түрүүн шаардагдах асуудал бол цагаа олсон шийдвэрт тулгуурлагдсан харилцааг үүсгэх явдал юм. Тухайн шийдвэрийн хүрээнд өөрийн итгэл үнэмшил, мэдлэгт тулгуурласан харилцааг бий болгоход хэл ярианы чадвар зайлшгүй шаардлагатай. Хэл ярианы чадвар дан ганц цэцэн мэргэндээ биш тухайн нийгмийн харилцааг шийдвэрлэхд ямар үүрэг /сурх, сургах.../ гүйцэтгэж байгаагаас шууд хамааралтай. Нөгөө талаас нийгмийн шаардлагад нийцсэн үйл ажиллагааг гэж тодорхойлж болох юм. Хэл ярианы чадвартай хүн тухайн нийгмийн харилцааны оношийг зөв оношлох шаардлагатай бөгөөд тулгарч буй асуудлыг даван туулахын тулд харилцааны харилцан хамаарлыг тогтоох бөгөөд хэл ярианы чадварыг зөв тогтоож суралцах нь зүйтэй байдаг. /Монгол ухаан, уламжлалд тулгуурласан харилцаа/

Өнөөгийн байдлаар Хууль сахиулахын их сургуулийн сонсогч оюутны хэл ярианы хөгжил, илтгэх чадварыг хөгжүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлага урган гарч ирсээр байна.

2011 оны 9 дүгээр сараас эхлэн сонсогч, оюутны ярих, илтгэх чадварыг



ажиглаж, ярилцаж байх зэргээр судлаж байхад ярих, илтгэх, чадвар учир дутагдалтай байгаа нь анхаарал татсан тул үүнийг бататгахын тулд холбогдох судалгааг хийсэн.

2012 оны 04-р сарын 01-ний байдлын судалгаагаар сонсогч, оюутны ярих, илтгэх чадварыг хөгжүүлхэд ашиглаж байсан уламжлалт ажлын хүрээнд тодорхой ажил зохиогдоогүй байна. Энэ нь илтгэх, мэтгэлцэн урлагийн чигэлэлээр хичээллэдэг дугуйлангуудын үйл ажиллагаа зогсонги байдалтай болсон. Энэ чиглэлээр доривтой уралдаан тэмцэн зохиогдоогүй байна. Өөрийн хичээл зааж байгаа ШШГС-ийн сонсогч, оюутны ярих чадварыг судалж байхад 3 дугаар курсын 60 сонсогчдын 15 нь буюу 25 хувь нь ярианы баялаг муу, 30 хувь нь дунд зэрэг, 25 хувь нь буюу 15 хувь нь ярианы баялаг сул гэсэн дүгнэлтэнд хүрсэн. Харин 2-р курсын 50 сонсогчдын 10 нь буюу 20 хувь нь ярих чадвартай гэсэн, 28 нь буюу 51.5 хувь нь ярианы баялаг муу гэсэн дүгнэлтэнд хүрсэн.

Илтгэх ярих чадвар хөгжүүлдэг клубт хичээллэдэг эсэх талаар судалгаа авахад 3, 2-р курсын 60 сонсогчдын 3 нь буюу 6.3 хувь нь хичээллэж байсан, үлдсэн 57 нь буюу 93.9 хувь нь огт хичээллэж байгаагүй, 2-р курсын 2 дугаар дамжааны 50 сонсогчдын 1 буюу 2 хувь нь хичээллэж байсан үлдсэн 49 буюу 98 хувь нь хичээллэж байгаагүй гэсэн судалгаа гарч ирсэн. Харин “Сургалтын нэгдсэн тогтолцоо судалгааны ажлын хүрээнд” ШШГБ-д ажиллаж байгаа төгсөгч нараас хөндлөнгийн байгууллага /шүүх, прокурорын/ байгууллагын алба хаагч нараас авсан судалгаагаар 150 албан хаагчийн 80 % нь ярих, чадвараа хөгжүүлэх шаардлагтай⁵³ гэсэн судалгааны дүн гарсан байdag.

Дээрхи асуудлыг анхааралдаа авч Шүүхийн шийдвэр гүйцэтгэх сургуулийн сонсогч, оюутнуудын сурах орчинг сайжруулах, сонсогчдын сурах идэвхи, ярилцах илтгэх чадварыг нээн хөгжүүлэх үүднээс сонсогч нараас идэвхи оролдлого сайтай сонсогч нарт нөлөөлж идэвхижүүлэх бусад сонсогч нарт зэрэг хандлага төлөвшүүлэх үүднээс сонсогч нарыг илтгэх ур чадварыг дээшлүүлэх үүднээс клуб байгуулан ажиллах нь зүйтэй гэж үзсэн.

Улмаар 2012 оны 3 дугаар сард анх “Маршал” клубын үйл ажиллагааг эхлүүлэн сургалтыг хичээлийн бус цагаар зохион явууллаж эхэлсэн.

Тэдний ярих чадварын түвшинг тогтоох үүднээс бүрэлдэхүүн сургуулийн захиргааны дэмжлэгтэйгээр “Парламентын мэтгэлцэн”-ийг анх удаа зохион явууллах болсон. Үлж ажиллагааны бэлтгэл ажлыг хангах үүднээс “Маршал клуб”-ын гишүүд сонсогч нараар дамжуулан судалгааг дахин авхад “Парламентын мэтгэлцэн”-ний талаархи ойлголтын талаар Дотоод хэргийн их сургуулийн нийт сонсогчдын хэмжээнд судалгаа авч нэгтгэн дүгнэсэн болно. Судалгаанд 1, 2, 3 дугаар дамжааны нийт 500 гаруй сонсогч хамрагдсан бөгөөд “Парламентын мэтгэлцэн”-ний талаар 50 орчим сонсогч буюу нийт сонсогч нарын 10 орчим хувь нь тодорхой хэмжээний төсөөлөлтэй байсан нь тэмцэн явууллахад учир дутагдалтайг харуулсан учир “Парламентын мэтгэлцэн”-ний талаархи мэдээллийг нийт сонсогч нарт бүрэлдэхүүн сургуулиудаар буюу мэдээлэлийн самбаруудаар дамжуулан хүргэж зарим сонсогч нарт клубын гишүүд холбогдох сургалтыг явуулсан.

⁵³ 2012 оны Сургалтын нэгдсэн тогтолцоо судалгааны ажлын багын тайлангаас



Хуучин нэрээр Дотоод хэргийн их сургуулийн аварга шалгаруулах анхдугаар “Парламентын мэтгэлцээн” тэмцээнийг зохион явууллахад бусад бүрэлдэхүүн сургуулиуд бүрэн хамрагдсан бөгөөд сонсогч оюутнуудын идэвх сайжирсан нь харагдаж байсан.

Дээрхи үйл ажиллагаа болон судалгаанд тулгуурлан дараах дүгнэлт, саналыг дэвшүүлж байна.

Нэгэнт сонсогч, оюутны ярих чадварыг “Клуб”-ээр дамжуулан хөгжүүлэх нь тухайн арга хэмжээнд хамрагдаж байгаа оюутнууд тасралтгүй хөгжлийн үйл явцад татагдан орж, сургах орчин нөхцөлийг зарим талаар бүрэлдүүлж байгаа нь ашиглагдсан.

Энэ чиглэлийн “Клуб”-д шинээр элсэж байгаа болон залгамж халааг бүрдүүлж өгснөөр үе үеийн сонсогч, оюутан оюун ухаанаа хөгжүүлэх үйл ажиллагаанд үнэтэй хувь нэмэр болно гэж бодож байна.

“Парламентын мэтгэлцээн”-ний үр дүнг ШШГС цаашид ярилцах, мэтгэлзэх зэрэг үйл ажиллагаагаар харилцааны соёлыг эзэмшсэн сонсогч нар судалгааны орчин болон практик байгуулагуудад ажиллахад бусадтай идэвхитэй үйл ажиллагаанд хамрагдан багаар ажиллах чадвар төлөвшинө гэдэгт итгэлтэй байна. Нөгөө талаас багш “Клуб” -ийн үйл ажиллагаанд тогтмол оролцож, идэвхжүүлж байх нь түүгээр дамжуулан сонсогч нарын итгэл үнэмшилийг төлөвшүүлэн тэдний зүгээс гаргасан санаачилага дээр үндэслэгдэн сурх орчинд учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэн, харилцааны дархлааг суулгах чухал алхам юм.

- Судалгааны үр дүнгээс харахад “Клуб”-ээр дамжуулан ярих, илтгэх үйл ажиллагааг улам их идэвхжүүлэх
- Энэ төрлийн уралдаан тэмцээнийг уламжлал болгон явуулах
- Цаашид энэ талын нөлөөлөл дээр үндэслэн сонсогч оюутны ярих чадварыг хөгжүүлэх
- Сургуулийн сонсогч нарын харилцааны болоод ярианы баялаг чадвар бүхий сонсогчдын нөлөөллийг бусад сонсогч оюутнуудад хүргэх
- Чадваргүй гэх томъёололд өртсөн сонсогч наортай ажиллах нэн тэргүүний тулгамдсан асуудлыг орхигдуулалгүй авч явах
- Төгсөгчид болон сонсогч нарын ярих илтгэх чадварын талаарх судалгааг нарийвчлан авах
- Бусад чиглэлийн клуб дугуйлантай хамтран ажиллах үйл ажиллагааг тогтмолжуулах зэрэг саналыг дэвшүүлж байна.